

БАТЛАВ:
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА

/гарын үсэг/

Г.ЧИНЗОРИГ

БАТЛАВ: "МАКСИМА МЕДИА"
ХХК-ийн ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/гарын үсэг/

З.ЭНХЖАРГАЛ

РАДИО, ТЕЛЕВИЗИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ХӨТӨЛБӨРТ
УИХ-ЫН 2021 ОНЫ НӨХӨН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ
МОНИТОРИНГ ХИЙХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

2021 оны 09 дугаар сарын
16-ны өдөр

№ *ГЗ/2147*

Улаанбаатар хот

Энэхүү **ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ** (цаашид "Гэрээ" гэнэ)-г нэг талаас Харилцаа Холбооны Зохицуулах Хороо, түүнийг төлөөлж Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга албан тушаалтай **З.ЭРДЭНЭЧУЛУУН** (цаашид "**ЗАХИАЛАГЧ**" гэх), нөгөө талаас Максима медиа ХХК (цаашид "**ГҮЙЦЭТГЭГЧ**" гэх) нар Монгол улсын Иргэний хуулийн 343 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг удирдлага болгон дараах нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Харилцаа холбооны зохицуулах хороо нь Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.22 дах заалт, Сонгуулийн ерөнхий хороо, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 18/22 дугаар тогтоолоор батлагдсан Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журамд заасан чиг үүргийн дагуу Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн 18, 28 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулиар радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгаанд хяналт тавьж ажиллах чиг үүргийн дагуу медиа судалгааны Максима Медиа ХХК-тай сонгуулийн сурталчилгаанд хяналт, мониторинг хийх зөвлөх үйлчилгээний ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэхээр харилцан тохиролцов.
- 1.2. Энэхүү гэрээгээр Зөвлөх үйлчилгээ үзүүлэх компани нь Монгол улсын их хурлын 18 болон 28 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн сурталчилгааны хугацаанд нэр бүхий радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгаанд Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журмын холбогдох зүйл, заалтын үзүүлэлтүүдээр хяналт, мониторинг хийх ажлыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн Захиалагчид мониторингийн тайлан гаргаж ирүүлэх нөгөө талаас Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөхтэй холбогдон талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.3. Гүйцэтгэгч нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.9, 46.11 дэх хэсгүүд болон Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журмын 2.7, 2.8 дах заалтуудыг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн Хуралдааны

- 20 дугаар тэмдэглэлийн хавсралтаар баталж, олон нийтэд мэдээлсэн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизийн хөтөлбөрт Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 39 болон 48 дугаар зүйлийн холбогдох хэсгүүдэд заасан үзүүлэлтүүдээр хяналт мониторинг хийх, мөн хуулийн 46.10 дахь хэсэгт заасан сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий бус радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлж байгаа эсэх талаар хяналт тавьж холбогдох тайлан мэдээг гэрээнд заасан үзүүлэлтүүдээр гаргаж, Захиалагчид өгнө.
- 1.4. Энэхүү гэрээнд зохицуулагдаагүй харилцааг Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.
 - 1.5. Гэрээний хүрээнд хийж гүйцэтгэх ажлын даалгаврыг гэрээний Хавсралтаар тодорхойлж өгнө.
 - 1.6. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

Хавсралт №1 Ажлын даалгавар

- Хяналт, мониторинг хийх үндэслэл, зорилго, хамрах хүрээ
- Мониторинг хийх үзүүлэлтүүд (хүснэгтээр үзүүлсэн байдал)
- Хяналт, мониторинг хийхэд баримлах зарчим
- Тайлан, тайлан гаргах хуваарь,
- Мониторингийн тайлангийн бүтэц, загвар
- Мониторинг-д хамрагдах телевизүүдийн жагсаалт

Хавсралт №2 Зөвлөхийн санал

- Үнийн санал
- Техникийн санал

2. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1. Энэхүү гэрээ нь 2021 оны 12 сарын 31 өдрийг хүртэл хүчинтэй байна.
- 2.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас Ажил гүйцэтгэгч нь ажлыг хугацаанд нь гүйцэтгэж чадахгүйд хүрвэл Захиалагчид нэн даруй мэдэгдэж Захиалагч нь нэмэлт хугацаа тогтоож өгнө.

3. АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР

- 3.1. Гэрээгээр гүйцэтгэх ажлын төлбөр нийт 18,600,000 /Арван найман сая зургаан зуун мянган төгрөг/ байх бөгөөд Захиалагч нь холбогдох хуулийн дагуу татвар, шимтгэлийг суутган олгоно.
- 3.2. Захиалагч ажил үйлчилгээний нийт төлбөрийг эцсийн тайлан нэгтгэл хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор Ажил гүйцэтгэгчийн Хас банкны 5000436771 тоот дансанд шилжүүлнэ.

4. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Ажил гүйцэтгэгчийг ажлын даалгавар болон шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.
- 4.2. Гэрээнд заасан хугацаа болон ажлын үр дүнг хүлээн авмагц ажил үйлчилгээний төлбөрийг төлөх үүрэгтэй.

7. БУСАД

- 7.1. Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурж захиалагч тал баталснаар хүчин төгөлдөр болно.
- 7.2. Талууд харилцан тохиролцож Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 7.3. Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЗАХИАЛАГЧ:

ХХЗХ-НЫ ЗУХАГ-ЫН ДАРГА

З.ЭРДЭНЭЧУЛУУН

Гарын үсэг _____

/Тамга/

ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН

ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

А. ЛУВСАН-ОЧИР

Гарын үсэг _____

ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН

ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ТОГТОХСҮРЭН

Гарын үсэг _____

Метро бизнес төв, А-корпус, 5 давхар

Бага тойруу, 6 дугаар хороо

Сүхбаатарын гудамж-13

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот,
14201

Утас: 304258

АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧ:

МАКСИМА МЕДИА ХХК-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ З.ЭНХЖАРГАЛ

Гарын үсэг _____

/Тамга/

Хаяг: Максима Медиа ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,

Энхтайваны өргөн чөлөө-23,

УВН төв 13 давхар

Утас: 77118887, 77116676

[Хас банк дахь 5000436771 тоот
төгрөгийн данс]

